



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/49

Батширээт сум

Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Журам шинэчлэн батлах тухай" хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хангаж журамд заагдсан мэдээллийг хугацаанд нь стандартын дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулахыг Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, Санхүү албаны дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

2. Шилэн дансанд байршуулах мэдээллийг бүрэн хугацаанд нь байршуулж буй эсэхэд хяналт тавьж тайланг улирал бүр графикт хугацаанд цахимаар илгээж байхыг Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Сумын хэмжээнд дансны хөтлөлтөд хяналт тавих, шилэн дансны хуулийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг жил бүр батлуулсан хэрэгжилтийг ханган ажиллаж улирал бүр тайлагнах, хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцуулж ажиллахыг Санхүүгийн алба, Төсөв, төрийн сангийн мэргэжилтэнд тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

232501098